



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 449

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” 202 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2018 оны 05/8517 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Улаангомын дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Ядмаагийн Содбаяр, Гэцэлийн Нямгэрэл, Төмөрхуягийн Золзаяа нарыг 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг судалж, үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг хараат бус гишүүдэд, мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авахыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН

ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002331

D:\Huraldaanii material\2018 он\2018.10.23\Togtool.docx